

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Амар амгалан байг

Хэдэн жилийн өмнө нэг өдөр надад ажил дээрх ажлаа цэгцэлсний дараа Солт Лэйк хотын өндөр настны асрамжийн газарт амьдардаг настай бэлэвсэн эмчлүүлэгчийг эргэж очих хүчтэй мэдрэмж төрсөн юм. Тэгээд би шууд тийшээ явлаа.

Би түүний өрөөнд ортол хэн ч байсангүй. Түүнийг хаана байж болохыг би үйлчилгээний ажилтнаас асуугаад, амралтын өрөөнд байгаа гэдгийг нь мэдэв. Тэр тэнд өөрийн эгч болон найзтайгаа ярилцаж байсан бөгөөд бид бүгдээрээ сайхан яриа өрнүүлж билээ.

Биднийг тэнд ярилцаж байх зуур нэгэн эр уг өрөөнд байдаг автомат худалдааны машинаас ирж ундаа авлаа. Тэр эр над руу хальт харснаа “Том Монсон уу?” гэж асуув.

“Тийм ээ” гэж би хариулаад “Харин та Хемингвэйтэй их адилхан харагдаж байна” гэлээ.

Олон жилийн өмнө намайг бишоп байх үед миний зөвлөх байсан Альфред Южин Хемингвэйн хүү Стэфэн Хемингвэй гэж өнөөх эр өөрийгөө танилцуулаа. Би түүний эцгийг Жин хэмээн дууддаг байлаа. Стэфэн надад түүний аав энд бие нь маш муу үхлийн ирмэгт байгаа гэж хэлэв. Өнгөрсөн хугацаанд Жин миний нэрийг их дууддаг байсан бөгөөд түүний гэрийнхэн надтай холбоо барих гэсэн боловч миний утасны дугаарыг олж чадахгүй байжээ.

Би тэнд байсан эгч нараас зөвшөөрөл аваад тэр даруй Стэфэнтэй хамт хуучин зөвлөхийнхөө өрөө

рүү явлаа. Түүний өрөөнд хүүхдүүд нь байв. Жиний эхнэр хэдэн жилийн өмнө нас барсан байлаа. Стэфэн надтай амралтын өрөөнд таарсан явдал аавыг нь нас барахаас өмнө би Жинтэй уулзан, түүний дуудсан дуудлагат хариулахыг хүссэн тэдний хүслийг Тэнгэрлэг Эцэг сонсон хариулсан хэрэг хэмээн тэд үзэж байлаа. Хэрвээ миний байсан өрөөнд Стэфэн орж ирээгүй бол би Жинийг энэ асрамжийн газар байсныг мэдэхгүй өнгөрөх байсан юм.

Бид Жинд адислал өгч, тэнд амар амгалангийн сүнс дүүрэн байв. Энэхүү дотно уулзалтын дараа би тэндээс гарч явсан билээ.

Дараагийн өдөр нь Стэфэн над руу утасдаад биднийг адислал өгснөөс 20 минутын дараа Жин Хемингвэйг нас барсан хэмээн дуулгав.

Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан намайг өндөр настны асрамжийн газар руу удирдан, хайрт найз Альфред Южин Хемингвэйтэй маань уулзуулсан Түүний сүнслэг нөлөөнд талархлаа илэрхийлэн залбирсан юм.

Сүнсээр дүүрэн, даруухнаар залбирч, санваарын адислал өгч мөн “Master, the Tempest Is Raging” дууллын үгсийг хамтдаа хэлж байсан тэр үдэш Жин Хемингвэйн бодож байсан зүйлсийн тухай би бодох дуртай. Уг дууллын үг нь ийм байдаг:

*Өө Адислагдсан Аврагч минь, Түр саатаач
Дахин намайг ганцааранг минь бүү орхиоч
Адислагдсан усан онгоцны зогсоолыг би баяртай-
гаар хийх болно
Аз жаргалтай эрэг дээрээ амрах болно.*

Энэ дуулал тайвшралын тухай гэрчилдэг тул би энэ дуулалд дуртай:

*Далайн догшин шуурга болж байсан ч
Ад зэтгэр эсвэл хүмүүн юу ч байсан,
Ус цалгилж завин дээр гарахгүй
Далай тэнгис, газар, тэнгэрийн Эзэн минь
Тэд бүгд Таны хүслийг даган
Амар амгалан байг¹*

Нулимс, зовлон бэрхшээл, айдас, уйтгар гуниг, хайртай хүнээ алдсан ганцаардал болон сэтгэлийн шаналал зэрэг нь амьдрал мөнх үргэлжилдэг гэдгийг нотолдог. Бидний Их Эзэн Аврагч эдгээр бүх зүйлийн амьд гэрч юм.² Ариун сударт байдаг Түүний “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” (Дуулал 46:10) гэдэг үгийг сана. Би энэ үнэнийг гэрчилж байна.

ЭШЛЭЛҮҮД

- “Master, the Tempest Is Raging” *Hymns*, № 105.
2. Ричард А.Эванс “So Let Us Live to Live Forever” 1971оны 7-р сарын 18 *New Era*-г үзнэ үү.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Энэ захиас хайртай хүмүүс нь нас барсан ба зовж зүдэрч буй хүмүүст тайвшралыг өгч чадна. Зааж буй хүмүүсийнхээ хэрэгцээнд нь тохируулан Ерөнхийлөгч Монсоны захиасаас гадна доор дурдсан судрын эшлэлүүдээс хуваалцаж болно: Иов 19:25;1 Коринт15:19–22; Мозая24:13–15; Сургаал ба Гэрээ122:7–9. Хэрэв та сүнслэгээр өдөөгдвөл зовлон бэрхшээлтэй үед чинь Аврагч хэрхэн тайвшруулж байсан тухай өөрийн туршлагаас хуваалцаарай.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Зүрх сэтгэлийг минь эдгээгээч

Кэлси Лидокс

Ах маань нас барсаны нэг жилийн дараах энэ өдөр би өөрийн амьдралын тухай эрэгцүүлэн бодлоо.

Би зүрх сэтгэлийн их өвдөлт мөн Бурханы өгсөн адислалуудын тухай эргэн саналаа.

Хайртай хүмүүсийнх нь үхэл адислалуудыг авчирдаг хэмээн хэлдэг хүмүүсийг би гайхдаг байв. Надад маш их гуниг зовлон авчирсан тэр зүйлийн төлөө баярлан талархах ёстой гэдгийг би ерөөсөө ойлгодоггүй байлаа. Тэр нэгэн шөнө миний бодол санааг бүхэлд нь өөрчилсөн юм.

Нэгэн шөнө дунд миний зүрх сэтгэл маш их шаналан сэрж билээ. Зүрх сэтгэлийн тэрхүү өвдөлт нь намайг бачимдуулж байв. Би өвдөг сөхрөөд Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирлаа. Би Есүс Христийн Цагаатгал болон Түүний гайхамшигт эдгээх хүчний талаар бүхий л амьдралынхаа турш заалгасаар ирсэн. Энэ үед миний итгэл шалгагдсан юм. Би үнэхээр итгэдэг үү? Би Тэнгэр дэх Эцэгээсээ зүрх сэтгэлийг минь эдгээхийг гуйлаа. Энэ өвдөлтийг ганцаараа үүрэхэд дэндүү хэцүү байсан.

Тэгээд дараа нь хайр, тайвшрал, амар амгалан мэдрэмжээр би дүүрлээ. Бурхан намайг тэвэрч, тэр их өвдөлтөөс хамгаалж байгааг би мэдэрсэн. Би ахыгаа санасан хэвээрээ л байсан ч үүнийг өөр нүдээр харах болсон юм. Энэхүү туршлагаас би маш их зүйлийг сурсан билээ.

Их Эзэний хайр ба амар амгалан бүх хүнд өгөгдөх боломжтой. Гагцхүү бид түүнээс хүртэх л хэрэгтэй.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Амар амгалан байхыг сонго

Бид амар амгалан, хүндэтгэлтэй байх юм бол Тэнгэрлэг Эцэгийнхээ талаар хүчирхэг гэрчлэлтэй болж, амар амгаланг мэдрэх болно хэмээн Ерөнхийлөгч Монсон хэлсэн. Мөн Ариун Сүнс биднийг бусдад туслах арга зам руу илүү ихээр удирдаж чадна.

Эцэг эхтэйгээ даруу байх нэг арга замыг ярилцах юмуу тэмдэглэж ав. Тэгээд энэ долоо хоногт үүнийгээ туршаад үзээрэй. Дараа нь өөрийнхөө тэмдэглэлийн дэвтэрт өөрийн мэдрэмж болон хүлээн авсан сүнслэг өдөөлтүүдийнхээ тухай бичиж тэмдэглээрэй.



ИДЭВХЖҮҮЛЭЛТ

Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн бүлэг өөрийн тань амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Итгэл, Гэр бүл, Халамж

Бидний Бошиглогч, Ерөнхий-лөгч Томас С.Монсон: “Бидний тусламж хэрэгтэй байгаа тэдэнд хүрч тэднийг илүү өндөрт, илүү сайн зам дээр гарахад нь туслаарай. . . Энэ бол Их Эзэний ажил. Бид Их Эзэний үйлсийг хийхдээ . . . Түүнээс тусламж авах эрхтэй байдаг”¹ хэмээн биднийг урамшуулсан юм.

Олон жилийн өмнө Лавэнэ Колл эгч айлчлагч багшийн хамтрагчтайгаа нэгэн идэвхгүй эгчийнд айлчлан очжээ. Хаалгыг нь тогштол гэрийн халаад өмсөн залуухан эх хаалгаа нээв. Тэр өвчтөй хүн шиг сул дорой харагдаж байлаа. Гэвч тэр өвчтэй биш харин архи уудаг болохыг нь тэд удалгүй ойлгожээ. Айлчлагч багш нар суугаад уг залуу ээжтэй ярилцсан юм.

Тэд тэднийхээс гарахдаа “Тэр Бурханы охин учраас бид түүнд туслах үүрэгтэй” хэмээн ярилцжээ. Тэгээд тэд өнөөх эмэгтэйд байнга айлчлан очдог болов. Айлчилж очих бүрдээ тэд сайн өөрчлөлтүүдийг харж чадаж байлаа. Тэд түүнийг Нийгмийн Халамжийн бүлэгт ирэхийг урив. Хэдийгээр тэр тийм дуртай байгаагүй ч Нийгмийн Халамжийн бүлэгт тогтмол ирдэг болжээ.

Түүнийг урамшуулан дэмжиж байсны ачаар тэр нөхөр болон охинтойгоо сүмд ирдэг болов. Нөхөр нь Ариун Сүнснийг мэдэрсэн бөгөөд “Би бишопын зөвлөсөн бүхнийг хийнэ” гэж хэлжээ. Одоо тэд сүмд идэвхтэй явдаг бөгөөд ариун сүмд мөнхийн холболтоо хийлгэсэн.²

Судруудаас

2 Нифай 18:32; Сургаал ба Гэрээ 84:106; 138:56

Бидний түүхээс

Замаасаа хазайсан хүмүүсийг Есүс Христийн сайн мэдээнд эргэн ирэхэд туслах нь Нийгмийн Халамжийн бүлгийн гишүүн хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйчүүдийн үүрэг байсаар ирсэн билээ. Ерөнхийлөгч Бригам Янг (1801-77) “Нэг нэгэндээ хайртай байцгаая, . . . мөн сохорсон тэдгээрийг өөрсдөд нь бэлдсэн замаа харах хүртэл нь хөтөлцгөө”³ хэмээн хэлжээ.

Юта мужийн Огден хотын эгч нар нэг нэгнээ хүчирхэгжүүлэхийн тулд гаргасан хичээл зүтгэлийн тухай Нийгмийн Халамжийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Элиза Р.Снөү талархалтайгаар мэдэгдсэн юм. “Би [дээд

амжилтуудын] номонд хэзээ ч бичигддэггүй маш олон [үйлчлэл] хийгдэж байдаг гэдгийг мэднэ” хэмээн тэрээр хэлжээ. Гэвч зүрх сэтгэл нь хөрсөн хүмүүст хүрч ажиллах эгч нарын ажил тэнгэрийн тэмдэглэлд бичигдэж байгаа гэдэг талаар тэрээр цааш нь “Ерөнхийлөгч Иосеф Смит хэлэхдээ: Энэ бүлэг бол бодгалиудыг аврахын тулд зохион байгуулагдсан юм. . . . Таны итгэл, сайхан сэтгэл, сайн үйлс болон үгс өөр нэгэн номд бичигдэж байгаа. . . . Юуг ч гээхгүй”⁴ хэмээжээ.

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон “Үйлчлэлийн ариун дуудлага” 2005 оны 5 сар *Лианхона* 55, 56
2. Нийгмийн Халамжийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлд Лавэнэ Коллын охиноос ирсэн захидал.
3. Бригам Янг *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 107.
4. Элиза Р.Снөү *Daughters in My Kingdom*, 83.

Би юу хийж чадах вэ?

1. Би идэвхгүй эгчээс Нийгмийн Халамжийн бүлэгтээ хамт явах уу гэж асуух итгэлтэй байна уу?
2. Миний айлчилж очдог эгч нар надаас сургаалын талаар асуулт асуухад надад ямар байдаг вэ?